



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/94

Алтрага

**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай
хуулийн хэрэгжилтийг хангах талаар авах
зарим арга хэмжээний тухай**

Монгол Улсын Засаг захиргааны нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архи дан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, аймгийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн А/324 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн санал авах (зөөврийн битүүлжилсэн саналын хайрцгаар болон санал авах байранд), хяналтын тооллого хийхтэй холбогдуулан сумын нутаг дэвсгэрт 2024 оны 06 дугаар сарын 27, 28, 29-ний өдрийг дуустал хугацаанд архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг, 06 дугаар сарын 28-ны өдөр соёл, урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төв ажиллахыг тус тус хориглосугай.

2. Тус өдрүүдэд дээрх төрлийн үйл ажиллагаа явуулахгүй байхыг төрийн байгууллага, аж ахуй нэгж, иргэдэд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч (дэслэгч Н.Очир-Эрдэнэ), Хүнс, ЖДҮ, Хоршоо хариуцсан мэргэжилтэн (Г.Бямбажаргал), багийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Энэхүү захирамжийг олон нийтэд суртчилж, мэдээлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрхзүйн мэргэжилтэн (М.Одхүү)-д даалгасугай.

ДАРГА



Г.ОДСЭР

Document-Zahiramg

6729010214